

Маргааны товч:

Иргэн Д.Янжинхорлоогоос Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд “Өмгөөлөгч Ж.Батхуяг өөрт нь хаяглагдсан Улсын ерөнхий прокурорын орлогчийн хариу мэдэгдэх хуудсыг хэвлэн нийтлүүлэхээр эх хувиар нь үйлчлүүлэгчдээ гаргаж өгсөн, ... худал мэдээлэл бүхий нотлох баримтгүй мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр түгээж, миний болон бусад төрийн албан хаагчдын нэр төрд халдаж, гүтгэсэн үйлдэл нь Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн” талаар гомдол гаргажээ.

Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн МТ/09 дүгээр тогтоолоор өмгөөлөгч Ж.Батхуягийг Өмгөөллийн тухай хууль, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчөөгүй гэж дүгнэж, түүнд холбогдох маргааныг хэрэгсэхгүй болгосон байна.

Энэхүү тогтоолыг гомдол гаргагч Д.Янжинхорлоо эс зөвшөөрч маргажээ.